



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/24

Шивээговь сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 46.1.3, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 2022 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хийгдэх “Сумын төв болон гудамж талбайн гэрэлтүүлэг нэмэх, гэрлэн чимэглэл хийх” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог зөвшилцсөнөөр дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- Үнэлгээний хорооны дарга: Ч.Сугармаа (Засаг даргын орлогч)
- Гишүүд: Б.Базаррагчаа (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний сум хариуцсан мэргэжилтэн)
- Иргэний төлөөлөл: Б.Даваадолгор (3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч)
- Нарийн бичгийн дарга: Д.Ганбат (2 дугаар багийн иргэн)
- Ц.Замбага (Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдаа авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. “Сумын төв болон гудамж талбайн гэрэлтүүлэг нэмэх, гэрлэн чимэглэл хийх” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хуулийн дагуу хариуцлагатай зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг үнэлгээний хорооны дарга (Ч.Сугармаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ